



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 90

Сангиндалай

Энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх
зардлын нэгж тариф батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тус сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан нэгж тарифыг үндэслэн хог хаягдлын үйлчилгээний хураамжаар өрх, иргэн аж ахуй нэгж байгууллагад үйлчлэхийг хог хаягдал цуглуулах, тээвэрлэх авто машин түрээслэгчдэд, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Д.Батбаяр), 7-р багийн Засаг дарга (Ж.Түвшинбаатар) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ЧУЛУУН

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн
дугаар 90 тогтоолын хавсралт



ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛЖ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ

№	Хог хаягдлын үйлчилгээний ангилал	Хэмжих нэгж	Нэгжээс авах хураамжийн хэмжээ / төгрөгөөр/
1	Гэр хороолол	1 тэвш	40000
		1 пошиг	4000
2	Орон сууц, амины орон сууц/ Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон/	1 өрх сард	4000
3	Албан байгууллага	1 байгууллага сард	20000
4	Иргэн, аж ахуй нэгж	1 тэвш	40000
		1 пошиг	4000
5	Уурын зуух	1 тэвш	30000
6	Хогийн цэг руу орох	1 авто машин тэвш	5000
		1 пошиг, 1 шуудай	2000
		5 тн дээш авто машин	20000
		Гэрээт ачигчийн авто машин төлбөргүй нэвтэрнэ.	